

КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2023 оны 4 сарын 30-ны өдөр

№23/01

Улаанбаатар хот

“КРИПТО ҮНДЭСТЭН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Кripto Үндэстэн ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 4 сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Кripto Үндэстэн ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2023 оны 4 сарын 30-ны өдөр

№23/02

Улаанбаатар хот

“КРИПТО ҮНДЭСТЭН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн хувьцааг хуваах, дүрэмд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.6 дахь заалт, “Крипто Үндэстэн” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны 4 сарын 30-ны өдрийн тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Крипто Үндэстэн” ХК-ийн нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 113,212 (нэг зуун арван гурван мянга хоёр зуун арван хоёр) ширхэг энгийн хувьцааны нэрлэсэн үнэ болон нэгж хувьцаа тус бүрийг 10,000 дахин хувааж, компанийг нэг бүр нь 0.01 (тэг зууны нэг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 1,132,120,000 (нэг тэрбум нэг зуун гучин хоёр сая нэг зуун хорин мянга) ширхэг энгийн хувьцаатай болгож өөрчлөн, тогтоосугай;
2. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор “Крипто Үндэстэн” ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн гаргасан хувьцааны нэрлэсэн үнэ 100 (нэг зуу) төгрөг байна. Компанийн нийт гаргасан энгийн хувьцаа 113,212 (нэг зуун арван гурван мянга хоёр зуун арван хоёр) ширхэг байх бөгөөд нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 11,321,200 (арван нэгэн сая гурван зуун хорин нэгэн мянга хоёр зуу) төгрөг байна” гэж заасныг “Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн гаргасан хувьцааны нэрлэсэн үнэ 0.01 (тэг зууны нэг) төгрөг байна. Компанийн нийт гаргасан энгийн хувьцаа 1,132,120,000 (нэг тэрбум нэг зуун гучин хоёр сая нэг зуун хорин мянга) ширхэг байх бөгөөд нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 11,321,200 (арван нэгэн сая гурван зуун хорин нэгэн мянга хоёр зуу) төгрөг байна” гэж өөрчлөн найруулсугай;
3. “Крипто Үндэстэн” ХК-ийн Хувьцаа хуваах төслийг Нэгдүгээр хавсралтаар баталсугай;
4. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон “Монголын хөрөнгийн бирж” ХК дахь үнэт цаасны болон компанийн бүртгэлд өөрчлөлт оруулах, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал Д.Чадраабал-д даалгасугай

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

"Крипто Үндэстэн" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын
30-ны өдрийн 23/02 тоот Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тогтоолын Хавсралт №1



КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ХУВААХ ТӨСӨЛ

1. КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУВААХ ҮНДЭСЛЭЛ АЧ ХОЛБОГДОЛ

1.1. Үндэслэл

1.1.1. Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл болон 63 дугаар зүйлийн дагуу компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар энэхүү төслийг хэрэгжүүлэх бүрэн үндэслэл бүрдсэн болно.

1.2. Хувьцаа хуваах үндсэн нөхцөл

1.2.1. Хувьцаа хуваах төслийг компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулснаар хувьцаа хуваах нөхцөл бүрдэнэ. Шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулан хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна. Улмаар "Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК болон "Монголын хөрөнгийн бирж" ХК дахь үнэт цаасны болон компанийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

1.3. Зорилго

1.3.1. Компанийн нийт гаргасан хувьцаа нь 113,212 ширхэг бөгөөд зах зээл дээр цөөн хэмжээний хувьцаа арилжигдаж байсан. Хувьцааны хэт өндөр үнэ нь зах зээл дээр хувьцаа чөлөөтэй арилжаалагдах хөрвөх чадварыг бууруулсан болно. Компанийн хувьцааг хувааснаар зах зээл дээрх хувьцааны хөрвөх чадвар сайжирч, арилжааны идэвх нэмэгдэн зах зээлийн зарчмаар компанийг хөрөнгө оруулагчдаар үнэлүүлнэ.

1.4. Шийдвэр

1.4.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 23/02 тоот тогтоол, тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн компанийн хувьцааны хөрөнгийн зах зээл дээрх арилжааг идэвхжүүлэх зорилгоор нэгж хувьцааг 10,000 ширхэгт хуваахаар шийдвэр гаргасан болно.

1.5. Ач холбогдол

1.5.1. Хувьцаа эзэмшигчдийн 1 ширхэг хувьцаа бүр нь 10,000 ширхэг болж өөрчлөгдөн тоо хэмжээ нэмэгдэж, өндөр тогтоод байгаа нэгж хувьцааны зах зээлийн ханш 10,000 хуваагдан шинэчлэн тогтоосноор хөрвөх чадвар нэмэгдэнэ.

1.5.2. Эзэмшиж буй хөрөнгө нь зах зээл дээр чөлөөтэй хөрвөх чадвартай болно.

- 1.5.3. Хувьцааны зах зээл дээрх арилжааны идэвх нэмэгдсэнээр компанийн үнэлгээг зах зээлийн жишгээр, бодитоор үнэлэх боломжтой болж, улмаар хөрөнгө оруулагчдын өмчилж буй хөрөнгийн үнэ цэнэ өснө.
- 1.5.4. Хувьцааны зах зээл дээрх арилжааны идэвх нэмэгдсэнээр компанийн үнэлгээг зах зээлийн жишгээр, бодитоор үнэлэх боломжтой болж, улмаар хөрөнгө оруулагчдын өмчилж буй хөрөнгийн үнэ цэнэ өснө.

2. ХУВЬЦАА ХУВААХ ТООЦООЛОЛ

- 2.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 23/02 тоот тогтоол, тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн 10,000 дахин хуваахаар шийдвэрлэсэн.
- 2.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн хувьцааг хувааснаар Крипто Үндэстэн ХК-ийн гаргасан хувьцаа дараах тооцооллын дагуу нэг бүр нь 0.01 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 1,132,120,000 ширхэг хувьцаа болж өөрчлөгдөнө.

	Хувьцаа хуваахаас өмнө	Хувьцаа хуваасны дараа
Нийт гаргасан хувьцаа	113,212 ширхэг	1,132,120,000 ширхэг
Нэрлэсэн үнэ	100 төгрөг	0.01 төгрөг
Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	11,321,200 төгрөг	11,321,200 төгрөг

3. ХУВЬЦАА ХУВААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ТЭДГЭЭРТ ҮҮСЭХ АЧ ХОЛБОГДОЛ

- 3.1. Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл болон 62 дугаар зүйлд 62.1.6-т “хувьцааг хуваах буюу нэгтгэх” гэж заасан бүрэн эрхийн дагуу Компани нь хувьцаа хуваах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.
- 3.2. Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийг үндэслэн “Монгол Хөрөнгийн бирж” ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтээ хүргүүлж, хувьцаа хуваах асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 3.3. Компанийн хувьцааг хуваах тухай “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарч, Улсын бүртгэлд холбогдох бүртгэлийг хийлгэснээр хувьцааг хуваах үйл ажиллагаа хэрэгжиж эхэлнэ.
- 3.4. Хувьцаа хуваах үйл ажиллагаа хэрэгжиж буйтай холбогдуулан компанийн хувьцааны арилжааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр түр зогсоож болно.
- 3.5. “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК болон “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д хувьцааг хуваах бүртгэлийн ажил

дуусгавар болсноор компанийн хувьцааны арилжааг хэвийн явагдаж боломжтой болно.

- 3.6. Хувьцаа хуваах үйл ажиллагаатай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн зүгээс авч хэрэгжүүлэх ямарваа нэг эрх, үүрэг үүсэхгүй бөгөөд энэхүү төслийн 3.5-д зааснаар арилжаа хэвийн явагдаж эхэлсэн нөхцөлд хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцаагаа биржийн арилжаагаар чөлөөтэй арилжих эрх нь нээлттэй болно.

4. ХУВЬЦАА ХУВААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ДУУСГАВАР БОЛОХ

- 4.1. Компанийн хувьцаа хуваах тухай төслийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулан, шийдвэр гаргуулснаар компанийн хувьцааг хуваах нөхцөл бүрдэнэ.
- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-д болон Санхүүгийн Зохицуулах хороонд танилцуулан хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна.
- 4.3. “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон “Монголын Хөрөнгийн бирж” ХК дахь үнэт цаасны болон компанийн Улсын бүртгэлд өөрчлөлт оруулснаар уг үйл ажиллагаа дуусгавар болно.

КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2023 оны 4 сарын 30-ны өдөр

№23/03

Улаанбаатар хот

“КРИПТО ҮНДЭСТЭН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны
зардлын төсвийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн, 62.1.16 дахь заалт, “Крипто Үндэстэн” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.8 дахь заалт, “Крипто Үндэстэн” ХК-ийн 2023 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтаар баталсугай;
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал Д.Чадраабал-д даалгасугай

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Крипто Үндэстэн ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын
30-ны өдрийн №23/03 тоот Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын Хавсраль №1



КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2023 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн (төгрөгөөр)
1	ТУЗ-ийн хурлын зардал	50,000	4	200,000
2	Хувьцаа эзэмшигчийн хурлын зардал	25,000,000	1	25,000,000
3	Томилолтын зардал	10,000,000	3	30,000,000
Нийт зардлын дүн				55,200,000